



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/140

Номгон

Малын халдварт өвчнөөс урьдчилан  
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а” дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт, “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” Монгол Улсын засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны хооронд зохион байгуулсугай.


2. Мал эмнэлгийн ерөнхий газраас баталсан төлөвлөгөөний дагуу малын дархлаажуулалтын ажлыг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулахыг сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн нэгжийн эмч нарт даалгасугай.

3. Дархлаажуулалт хийснээс хойш 28 хоногийн хугацаанд тухайн малчны хотноос мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд гаргаж борлуулах, нөөц бүрдүүлэхийг хориглосугай.

4. Дархлаажуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Т.Хишигбаатар/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН